

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ
ХУУЛИЙН 26 ДУГААР ЗҮЙЛД
ЗААСАН ТҮР СААТУУЛАХ
ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН
ХУУЛИЙН ЦЭЦЭД ХҮРГҮҮЛЭХ

AMICUS ТОЙМ

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Эмнести Интернэшнлийн Хэвлэл

Эмнести Интернэшнлээс 2024 онд анхлан хэвлэв.

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар

Петер Бененсоны Байр,

Истон Гудамж, 1

Лондон WC1X 0DW

Их Британи

www.amnesty.org

© Copyright Amnesty International Publications 2024

Эх хэл: Англи

Их Британи дахь Эмнести Интернэшнлийн Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас хэвлэв.

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэхүү хэвлэлийн аль нэг хэсгийг урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр электрон, механик, зураг, бичлэг гэх зэрэг аливаа хэлбэрээр хуулбарлах, хайлтын системд байршуулах, шилжүүлэхийг хориглоно.

Эмнести Интернэшнл нь хүний эрхийн асуудлаар кампанит ажил өрнүүлдэг дэлхийн 150 гаруй орны 10 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн даян дэлхийн хөдөлгөөн юм. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад олон улсын хүний эрхийн баримт бичгээр хамгаалагдсан эрхийг хүн бүрт эдлүүлэх нь бидний эрхэм зорилго. Бид хүний эрхийн зөрчлийг эцэс болгохын тулд судалгаа, кампанит ажил, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг. Эмнести Интернэшнл нь аливаа засгийн газар, улс төрийн үзэл, эдийн засгийн ашиг сонирхол болон шашнаас хараат бус болно. Бидний үйл ажиллагаа ихэвчлэн гишүүнчлэлийн хураамж, олон нийтийн хандиваар санхүүждэг.

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



АГУУЛГА

I	ТАНИЛЦУУЛГА	3
II	БАЙГУУЛЛАГЫН AMICUS CURIAE ХҮРГҮҮЛЭХ СОНИРХОЛ	4
III	МОНГОЛ УЛС ДАХЬ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭРЭГЛЭЭ	4
IV	СААТУУЛАХ НЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАСАХ ЭХЛЭЛИЙН ЦЭГ	5
V	ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХ ЗҮЙД НИЙЦСЭН НӨХЦӨЛДЛ СААТУУЛАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ЁСНЫ ХЭМЭЭН ҮЗНЭ	7
VI	СААТУУЛАХ АЖИЛЛАГАА НЬ ЭРХ ЗҮЙН ТОДОРХОЙ БАЙХ ЗАРЧИМД НИЙЦСЭН, ДУР ЗОРГЫН ҮЙЛДЛЭЭС АНГИД БАЙХ ЁСТОЙ	
VII	СААТУУЛАГДСАН ХҮН БҮРТ ЦАГДАН ХОРЬСОН ШАЛТГААНЫ ТАЛААР АЛЬ БОЛОХ БОЛОМЖИТ ХУРДАН ХУГАЦААНД МЭДЭГДЭЖ, ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХИЙГ ХАНГАХ ЁСТОЙ	8
VIII	ДУР ЗОРГООР СААТУУЛАГДСАН ХҮН БҮР ЗӨРЧИГДСӨН ЭРХЭЭ СЭРГЭЭЛГЭХ ЭРХТЭЙ БАЙХЫГ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙГЭЭР ШААРДДАГ	10
IX	ДҮГНЭЛТ	11
X	ХАВСРАЛТ	12

I. ТАНИЛЦУУЛГА

1. Монгол Улсын Үндсэн хуулийн шүүх(Цэц) (цаашид “Үндсэн хуулийн цэц” гэх)-ээс 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдөр ирүүлсэн мэргэжлийн дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийн дагуу энэхүү хариуг Эмнести Интернэшнлээс хүргүүлж байна. Үндсэн хуулийн цэцээс Цагдаагийн албаны тухай хуулийн Түр саатуулахтай холбоотой харилцааг зохицуулсан 26 дугаар зүйлтэй холбоотойгоор албан бичгийн 2.1-2.7-д жагсаасан асуултуудад (энэ баримт бичигт хавсаргасан) хариулт өгөхийг Эмнести Интернэшнлээс хүссэн.
2. Эмнести Интернэшнл энэхүү amicus curiae-д хүнийг саатуулах, тэр дундаа хүн бүрийн эрх чөлөөтэй, халдашгүй байх эрхийн талаарх олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн хууль, хэм хэмжээний талаар мэдээлэл хүргүүлэн Үндсэн хуулийн цэцэд дэмжлэг үзүүлж байна.

II. БАЙГУУЛЛАГЫН AMICUS CURIAE ХҮРГҮҮЛЭХ СОНИРХОЛ

3. Эмнести Интернэшнл нь хүний эрхийн олон улсын төрийн бус байгууллага юм. Бид Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын хэрэгжилтийг баталгаажуулах, хууль тогтоомжийг олон улсын хүний эрхийн эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх, хүний эрхийн хэм хэмжээг боловсронгуй болгох, хүний эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг. Эмнести Интернэшнл нь Монгол Улс зэрэг дэлхийн 150 гаруй улсын 10 сая гаруй гишүүн, идэвхтэн, дэмжигчдийг эгнээндээ нэгтгэсэн хөдөлгөөн юм. Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл, эдийн засгийн ашиг сонирхол, шашнаас хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг.
4. Эмнести Интернэшнл дээрх зорилгодоо хүрэхийн тулд олон улсын хүний эрхийн эрх зүйд улс орнуудын хууль тогтоомж нийцэж буй эсэхэд мониторинг хийх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор судалгаа, нөлөөлөл, стратегийн өмгөөлөл хийж, хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эрх нь зөрчигдсөн хүмүүсийн төлөө шударга ёсыг шаарддаг.
5. Эмнести Интернэшнл сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд олон улсын болон бүс нутгийн шүүхээс олон улсын эрх зүйн суурь асуудлыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор amicus curiae болон бусад гуравдагч этгээдийн тайлбар, мэдээлэл хүргүүлэх зэргээр нийтийн эрх ашгийн өмгөөллийн чиглэлээр арвин туршлага хуримтлуулсан. Тухайлбал, бид Олон улсын Эрүүгийн Шүүх, Европын Хүний Эрхийн Шүүх, Африкийн Хүний Эрхийн Шүүх, Америк хоорондын Хүний Эрхийн Шүүхийн үйл ажиллагаанд оролцож дэмжлэг үзүүлж байсан. Түүнчлэн, Бүгд Найрамдах Солонгос улсын Үндсэн хуулийн шүүх, Бангконгийн Иргэний шүүх, Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүх, Мексикийн Шударга ёсны Үндэсний Дээд Шүүх, Их Британий Дээд Шүүх, АНУ-ын Дээд Шүүх зэрэг үндэсний шүүхийн байгууллагаас шийдвэрлэсэн хэд хэдэн хэрэгт нэхэмжлэл гаргах, amicus curiae болон бусад гуравдагч этгээдийн тайлбар хүргүүлж байсан.
6. Шударгаар шүүлгэх эрхийн гарын авлагыг боловсруулах зэргээр Эмнести Интернэшнл нь дур зоргоор саатуулах асуудал, шударгаар шүүлгэх эрхийн чиглэлээр олон жил ажилласан.¹ Тус гарын авлага нь хүнийг баривчлан саатуулах үед хэрэглэвэл зохих шударгаар шүүлгэх эрхийн олон улсын болон бүс нутгийн хэм хэмжээний талаарх практик зааварчилгааг агуулсан бөгөөд уг эрхийг хүний эрхийн байгууллагууд, олон улсын шүүхээс хэрхэн тайлбарласныг тэмдэглэсэн. Дээрх гарын авлагад тайлбарласанчлан, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, эсхүл эрх зүйн маргааныг шийдвэрлэх тогтолцоо нь шударга ёсны талаарх олон улсын хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг шалгахад оролцож буй хэн бүхнийг практик зөвлөмжөөр хангахыг зорьсон. Түүнчлэн шүүх хуралдааныг ажиглагч, тодорхой хэргийг шударгаар шийдвэрлэсэн эсэх, тухайн улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо нь шударгаар шүүлгэх эрхийн олон улсын хэм хэмжээг хүндэтгэх баталгааг хангаж байгааг үнэлэхийг хүссэн хүн бүрт зориулсан юм. Уг гарын авлага нь хууль боловсруулагчид, шүүгч, прокурор, хуульчдад гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн болох боломжтой.
7. Эмнести Интернэшнл нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр хүчтэй, тууштай ажиллах сонирхолтой тул маргаан шийдвэрлэхтэй холбоотой олон улсын эрх зүйн өргөн хүрээний асуудлаар Үндсэн хуулийн цэцэд туслалцаа үзүүлэх бүрэн боломжтой.

¹ Amnesty International, Fair Trial Manual – Second Edition (Index: POL 30/002/2014), April 9 2014, [amnesty.org/en/documents/pol30/002/2014/en/](https://www.amnesty.org/en/documents/pol30/002/2014/en/)

III. МОНГОЛ УЛС ДАХЬ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭРЭГЛЭЭ

8. Монгол Улс нь Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (ИУТЭОУП) болон түүний Нэмэлт II протокол, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц болон түүний Нэмэлт протокол, Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын Конвенц, түүний хянан шалгах процедур зэрэг олон улсын хүний эрхийн суурь гэрээний оролцогч тал юм.
9. Монгол Улсын соёрхон баталсан, эсхүл нэгдэн орсон олон улсын гэрээ, түүнчлэн олон улсын заншлын эрх зүй нь тус улсын үндэсний эрх зүйн нэг хэсэг юм.
10. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд тухайлан заасанчлан:
 - (1) Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.
 - (2) Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.
 - (3) Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.
 - (4) Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.
11. Иймд олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүргээ төр зөрчихөөс Монгол Улсын эрх зүйд харьяалагдах бүх хүн хамгаалагдсан гэж үзэх бөгөөд олон улсын гэрээгээр хамгаалагдсан эрх, эрх чөлөөг дотоодын шүүхээр хамгаалах боломжтой.

IV. СААТУУЛАХ НЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАСАХ ЭХЛЭЛИЙН ЦЭГ

12. Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй байх эрхтэй. Уг эрхийг ИУТЭОУП-ын 9(1) дэх заалтаар хамгаалсан бөгөөд олон улсын хүний эрхийн гэрээгээр өргөн хүрээнд хүлээн зөвшөөрсөн.²
13. ИУТЭОУП-ын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий НҮБ-ын Хүний Эрхийн Хороо ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйлийн хувь хүн болон нийгэмд үзүүлэх чухал ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн.³ Эрх чөлөө болон хүний халдашгүй байдал нь чухал ач холбогдолтой эрх бөгөөд эдгээр эрхийг хасах нь түүхийн туршид хүний бусад эрхийг эдлэх явдлыг дордуулах үндсэн арга хэрэгсэл болсоор ирснийг НҮБ-ын Хүний Эрхийн Хороо (ХЭХ) онцолсон.⁴
14. Эрх чөлөөг хасах нь хүнийг эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцах урьдач эхлэлийн цэг болдог. Тиймээс НҮБ-ын ХЭХ-оос аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, эсхүл цагдан хоригдсон хүмүүсийг хорих арга, практик, зохион байгуулалт болон тэдэнтэй харьцах үйл ажиллагаанд системтэйгээр хяналт хэрэгжүүлэх нь эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцах явдлаас урьдчилан сэргийлэх үндсэн алхам болохыг тэмдэглэсэн.⁵
15. Олон улсын хүний эрхийн эрх зүй, хэм хэмжээнд зааснаар эрх чөлөөг хасах ойлголтыг тодорхойлох хэд хэдэн нийтлэг агуулга байдаг.
 - (1) ~~Нэгдүгээрт~~, төрөөс үндэслэл бүхий тохиолдолд л тухайн этгээдийн зорчих эрх чөлөөг нь хязгаарлах үйлдэл хийсэн байх шаардлагатай. НҮБ-ын ХЭХ-ны тодорхойлсноор эрх чөлөө гэдэгт үйлдэл хийх ерөнхий эрх чөлөө бус, харин хүнийг бие махбодын хувьд хязгаарлах, хорих явдлаас ангид хамгаалагдсан байх явдал юм”.⁶ НҮБ-ын ХЭХ цааш тайлбарлахдаа “эрх чөлөөг хасах ойлголтод ИУТЭОУП-ын 12 дугаар зүйлд заасан зорчих эрх чөлөөнд хөндлөнгөөс нөлөөлөхөөс илүүтэйгээр хязгаарлагдмал орон зайд хөдөлгөөнийг илүү хатуу хязгаарлахыг хамруулна.” Эрх чөлөөг хасах гэх ойлголтод цагдаагийн албадан саатуулах ажиллагаа (arraigo), түр саатуулах, хязгаарлалт

² See for example, article 3 of the Universal Declaration of Human Rights, article 7(1) of the American Convention on Human Rights, article 5(1) of the European Convention for the Protection of Human Rights and Fundamental Freedoms, article 6 of the African Charter on Human and Peoples Rights; and article 14(1) of the Arab Charter on Human Rights.

³ UN Human Rights Committee (HRC), General Comment 35, Article 9 (Liberty and Security of Person), 16 December 2014, UN Doc CCPR/C/GC/35, para

⁴ UN Human Rights Committee (HRC), General Comment 35, Article 9 (Liberty and Security of Person), 16 December 2014, UN Doc CCPR/C/GC/35, para 2.

⁵ UN Human Rights Committee, General Comment 20, Article 7 (Prohibition of torture and cruel treatment or punishment), UN Doc. HRI/GEN/1/Rev.1, para. 11.

⁶ UN Human Rights Committee (HRC), General Comment 35, Article 9 (Liberty and Security of Person), 16 December 2014, UN Doc CCPR/C/GC/35, para 3.

тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ, яллагдагчаар татаж цагдан хорих, ял шийтгэгдсэний дараа хорих, гэрийн хорионд байлгах, захиргааны журмаар цагдан хорих, албадан эмчлэх, хүүхдийг улсын асрамжид авах, нисэх онгоцны буудлын тусгай бүсэд саатуулах, албадан тээвэрлэх (онцолж авав) гэх мэт арга хэмжээг хамруулна.⁷ Үүнтэй холбоотойгоор Европын Хүний Эрхийн Шүүхээс “тодорхой хязгаарлагдмал орчинд хүнийг удаан хугацааны турш байлгах”⁸-ыг эрх чөлөөг хасах ойлголтын чухал элементийн нэг хэмээн тайлбарласан.

- (2) Хоёрдугаарт, тухайн хүн өөрийг нь саатуулах явдлыг зөвшөөрөөгүй үед хэрэгжүүлэх шаардлагыг эрх чөлөөг дур зоргоор хасах хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллага болох НҮБ-ын Дур зоргоор баривчлан саатуулах асуудлаарх ажлын хэсэг,⁹ НҮБ-ын ХЭХ¹⁰ болон Европын Хүний эрхийн Шүүхээс¹¹ тус тус онцлон тэмдэглэсэн байдаг.

16. Эрх чөлөөг хасах нь төрийн эрх бүхий этгээд хувь хүнийг албадлага хэрэглэн чөлөөтэй орхин явах эрхгүйгээр, цагдаагийн байранд хүргэж, суллагдах хүртэл нь тухайн газраа байлгаж байгаагаар тодорхой илэрнэ.¹² Мэдүүлэг өгсөнийхөө дараа тухайн газрыг орхин явах эрхгүй болсон сэжигтэнг холбогдох байгууллагын хяналтад орсон цагаас нь эхлэн саатуулагдсанд тооцно.¹³ Эрх чөлөөг хасах нь орон зайн хувьд хаана ч тохиолдож болох бөгөөд дур зоргоор баривчлан саатуулах явдлаас хамгаалахын тулд баривчилсан, эсхүл түр саатуулсан, цагдан хорьсон хэмээн албан ёсоор тодотгох шаардлагагүй.¹⁴ Үүний нэгэн адилаар ямар ч хугацаанд, тэр ч байтугай хэдхэн цагаар эрх чөлөөг нь хязгаарласныг ч саатуулсан хэмээн үзнэ.¹⁵ “Эрх чөлөөг хасах” нэр томъёонд тухайн этгээдийг анхлан саатуулсан үеэс баривчлах, шүүх хуралдаанаас өмнө болон дараа нь цагдан хорьсон хугацааг хамруулахыг НҮБ-ын Дур зоргоор баривчлан саатуулах асуудлаарх ажлын хэсэг хүлээн зөвшөөрсөн. Түр саатуулах, хамгаалах байранд байлгах нь эрх чөлөөг хасах ойлголтод мөн хамаарна.¹⁶ Холбогдох цаг хугацааг тодорхойлох зорилгоор авч үзвэл саатуулах хугацааг тухайн хүний эрх чөлөөг хязгаарласан үеэс эхлэн тоолно.

V. ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХ ЗҮЙД НИЙЦСЭН НӨХЦӨЛД Л СААТУУЛАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ЁСНЫ ХЭМЭЭН ҮЗНЭ

17. Хүний хувийн эрх чөлөө нь жам ёсных биш. ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйлд зааснаар эрх чөлөөг хасахдаа хууль дээдлэх ёсыг хүндэтгэх ёстой.¹⁷ НҮБ-ын ХЭХ-оос “баривчлах, цагдан хорих ажиллагаа нь дур зоргын бус, хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдах бөгөөд саатуулсан үндэслэлийн талаарх мэдээллийг өгөхийн зэрэгцээ шүүхийн хяналт хэрэгжих боломжтой байх шаардлагатай”¹⁸ болохыг баталгаажуулсан. Хүний эрх чөлөөг хасаж болох зөвшөөрөх нөхцөлийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай. Баривчлах, саатуулах эрх олгосон дотоодын хууль тогтоомж болон баривчлах, саатуулах журмыг тогтоосон дотоодын хууль тогтоомж нь олон улсын хэм хэмжээнд нийцсэн байх ёстой.¹⁹ Хуулиар баривчлахыг зөвшөөрөөгүй гэмт хэрэгт холбогдуулан баривчлах,²⁰ мөн

⁷ Ibid. para 5.

⁸ European Court of Human Rights, Decision, *Storck v Germany*, Application no. 61603/0016 June 2005, para 74.

⁹ Working Group on Arbitrary Detention, Report, United Nations Basic Principles and Guidelines on Remedies and Procedures on the Right of Anyone Deprived of Their Liberty to Bring Proceedings Before a Court, 6 July 2015, UN Doc A/HRC/30/37.

¹⁰ UN Human Rights Committee (HRC), General Comment 35, Article 9 (Liberty and Security of Person), 16 December 2014, UN Doc CCPR/C/GC/35, para 6

¹¹ European Court of Human Rights, Decision, *Storck v Germany*, Application no. 61603/0016 June 2005, para 74.

¹² UN Human Rights Committee, Decision, *Mursalov et al v. Azerbaijan*, 13 January 2023, UN Doc CCPR/C/136/D/3153/2018, para 9.7.

¹³ UN Working Group on Arbitrary Detention, Report, Visit to Mongolia, 5 July 2023, UN Doc. A/HRC/54/51/Add.2, para 38.

¹⁴ Working Group on Arbitrary Detention, Report, United Nations Basic Principles and Guidelines on Remedies and Procedures on the Right of Anyone Deprived of Their Liberty to Bring Proceedings Before a Court, 6 July 2015, UN Doc A/HRC/30/37.

¹⁵ UN Working Group on Arbitrary Detention, Report, Visit to Mongolia, 5 July 2023, UN Doc. A/HRC/54/51/Add.2, para 37.

¹⁶ Working Group on Arbitrary Detention, Report, United Nations Basic Principles and Guidelines on Remedies and Procedures on the Right of Anyone Deprived of Their Liberty to Bring Proceedings Before a Court, 6 July 2015, UN Doc A/HRC/30/37, para 9.

¹⁷ UN Human Rights Committee (HRC), General Comment 35, Article 9 (Liberty and Security of Person), 16 December 2014, UN Doc CCPR/C/GC/35, para 10.

¹⁸ UN Human Rights Committee (HRC), General Comment 8, Article 9 (Liberty and Security of Person), 30 June 1982, UN Doc CCPR/C/GC/35, para 4.

¹⁹ Inter-American Commission on Human Rights, Resolution 1/08, 13 March 2008, Principle IV of the Principles and Best Practices on the Protection of Persons Deprived of Liberty in the Americas. See also, *A v Australia*, Human Rights Committee, Decision, UN Doc. CCPR/C/59/D/560/1993 (1997) para 9.5; European Court of Human Rights, *Bozano v France*, Application no. 9990/82, 1986, para 54; European Court of Human Rights, Decision, *Lukanov v Bulgaria*, Application no. 21915/93, (1997) para 41, European Court of Human Rights, Decision, *Baranowski v Poland*, Application no. 28358/95, 2000, paras 50-52; European Court of Human Rights, *Medvedyev and Others v France*, Grand Chamber decision, Application no. 3394/03, 2010, paras 79-80; Inter-American Court of Human Rights, Decision, *Gangaram-Panday v Suriname*, 1994 paras 46-47; *Alfonso Martin Del Campo Dodd v Mexico* 12.228, Report 117/09, Inter-American Commission on Human Rights, 2009, para 22.

²⁰ UN Human Rights Committee, Decision, *Latifulin v Kyrgyzstan*, 10 May 2010, UN Doc. CCPR/C/98/D/1312/2004, para 8.2.

заасан хугацаанаас хэтрүүлэн саатуулах²¹ зэрэг нь дотоодын хууль тогтоомжид нийцээгүй баривчлах, саатуулах ажиллагааны жишээ болно.

18. Гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэл бүхий сэжиг бүрдсэн нөхцөлд тухайн этгээдийг эрх бүхий байгууллагад авчрах нь баривчлах арга хэмжээг хүлээн зөвшөөрөх үндэслэл болно хэмээн олон улсын эрх зүйд үздэг.²² Европын Хүний Эрхийн Шүүхээс “тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй объектив ажиглалтын илтгэх факт, эсхүл мэдээлэл байгаа нөхцөлд”²³ баривчлах арга хэмжээг зөвтгөх сэжиг бүрдсэн хэмээн үзнэ гэжээ. Түүнчлэн, үндэслэл бүхий сэжиг нь гэмт хэрэг үйлдсэн хэмээн сэжиглэж байгаа тухайн гэмт үйлдэлтэй холбоотой байх шаардлагатай.²⁴ Хэрэв гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор урьдчилан саатуулахыг зөвшөөрсөн хуулийн дагуу тухайн хүнийг саатуулсан боловч мөрдөн шалгах ажиллагаа явуулаагүй, эсхүл гэм буруутай хэмээн үзээгүй тохиолдолд тухайн саатуулах арга хэмжээ нь эрх чөлөөг зөрчсөн үйлдэл болно хэмээн Европын Хүний Эрхийн Шүүх дүгнэсэн.²⁵ Мөн Америкийн Хүний Эрхийн Конвенц, Америкийн Хүний Эрх болон Үүргийн талаарх Конвенцын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Америк хоорондын Хүний Эрхийн Комиссын үзсэнээр захиргааны журмаар саатуулах арга хэмжээг²⁶ зөвхөн хууль сахиулах, эрүүл мэнд болон бусад нийтийн ашиг сонирхлыг хангах зэрэг зайлшгүй үндэслэлээр хэрэгжүүлж болох бөгөөд эрх чөлөөг хасах ойлголт нь зөвхөн нарийн тодорхойлсон гарцаагүй нөхцөлд, шүүхийн хяналтын дор, тодорхой хугацаагаар, урьдчилан сэргийлэх зорилгоор саатуулахыг зөвшөөрнө²⁷ гэжээ. Эрүүгийн эрх зүйн хамгаалалтыг үгүйсгэн ашиглагдах боломжтой гэсэн үндэслэлээр зарим тохиолдолд захиргааны, эсхүл аюулгүй байдлын саатуулах арга хэмжээ хэмээн нэрлэдэг урьдчилан сэргийлэх саатуулах арга хэмжээг хэрэгжүүлэхийг Эмнести Интернэшнл нь эсэргүүцдэг.
19. Улс орнууд эрүүгийн хэрэгтэй холбоогүйгээр захиргааны журмаар саатуулах арга хэмжээг өргөжүүлэх нь эрх чөлөөтэй байх эрхийг дур зоргоор хасах ноцтой эрсдэлтэй гэж НҮБ-ын ХЭХ үздэг.²⁸ Гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог хамааруулан аюул заналыг арилгах бусад үр дүнтэй арга хэмжээг авах боломжтой атал захиргааны саатуулах арга хэмжээ авах нь дур зоргоор саатуулахтай адил.²⁹
20. Ерөнхийдөө шүүхээс өмнө урьдчилан хорих нь онцгой арга хэмжээ байх шаардлагатай бөгөөд үндэслэлтэй, зайлшгүй нөхцөлд, хуульд заасан тохиолдолд, хоёрдмол агуулга, өргөтгөсөн хэм хэмжээгүйгээр, тухайлсан шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлнэ. Шүүхээр хэрэг нь шийдвэрлэх шатанд байгаа хүний эрх чөлөөг зайлшгүй тохиолдолд, тухайн нөхцөл байдалд тохируулан хасах явдлыг баталгаажуулах төрийн үүрэг хэвээр хадгалагдах бөгөөд тухайн хүнийг суллах нь оргон зугтаах, бусдад хохирол учруулах, эсхүл нотлох баримтыг устгах, мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулах гэх зэрэг өөр арга хэлбэрээр арилгах боломжгүй бодит эрсдэлийг бий болгоно гэдгийг тогтоосон байх шаардлагатай.³⁰ Түүнчлэн, шүүхээс өмнө саатуулах хугацаа нь буруутгаж байгаа гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хугацаанд хүрсэн тохиолдолд тухайн этгээдийг суллах ёстой.³¹
21. Нэг эсвэл хэд хэдэн хуульчлагдсан гэмт хэрэг, зөрчилд буруутгагдаж байгаагаас бусад тохиолдолд төр хэнийг ч цагдан хорих ёсгүй; энэ хязгаараас давчихвал ихэнх тохиолдолд тухайн үйлдэл нь зайлшгүй бус, хэр хэмжээнээс хэтэрсэнд тооцогдоно гэдгийг Эмнести Интернэшнл онцлон дурдаж байна. Дээр дурдсан хуульчлагдсан гэмт хэрэг гэдэгт хууль ёсны болон хуулийн тодорхой байх

²¹ Working Group on Arbitrary Detention, Opinion 10/2009 (Venezuela), UN Doc.A/HRC/13/30/Add.1 (2009) pp172-179 paras 52(b)-53; Alfonso Martín Del Campo *Dodd v Mexico* (12.228, Report 117/90), Inter-American Commission (2009) paras 22-25.

²² Article 5(1) of the European Convention on Human Rights.

²³ European Court of Human Rights: *Fox, Campbell and Hartley v United Kingdom* (Application nos. 12244/86, 12245/86, 12383/86), (1990) para 32; *Murray v United Kingdom*, Grand Chamber, Application no. 14310/88, 1994, paras 50-63. See also Guideline VII(1) of the Council of Europe Guidelines on Human Rights and the Fight Against Terrorism, 11 July 2002; European Commission against Racism and Intolerance, General Policy Recommendation No. 11 on Combating Racism and Racial Discrimination in Policing, 29 June 2007, para 3.

²⁴ European Court of Human Rights, Decision, *Wloch v Poland* Application no. 27785/95, (2000) paras 108-109; *Kandzhov v Bulgaria* Application no. 68294/01, 2008, paras 52-62.

²⁵ European Court of Human Rights, *Jėčius v Lithuania* Application no. 4578/97, 2000, paras 47-52.

²⁶ Administrative detention refers to measures under which individuals are detained by order of state authorities without intent to prosecute them in a criminal trial.

²⁷ Inter-American Commission on Human Rights, Report on Terrorism and Human Rights, Executive Summary, OEA/Ser.L/V/II.116, Doc. 5 rev.1 (22 October 2002), paras. 23, 25.

²⁸ UN Human Rights Committee (HRC), General Comment 35, Article 9 (Liberty and Security of Person), 16 December 2014, UN Doc CCPR/C/GC/35, para 15, referring to HRC concluding observations: Colombia (UN Doc. CCPR/C/COL/CO/6, 2010), para. 20, and Jordan (UN Doc. CCPR/C/JOR/CO/4, 2010), para. 11.

²⁹ UN Human Rights Committee (HRC), General Comment 35, Article 9 (Liberty and Security of Person), 16 December 2014, UN Doc CCPR/C/GC/35, para 15.

³⁰ Human Rights Committee, *Marinich vs. Belarus*, 19 August 2010, UN Doc. CCPR/C/99/D/1502/2006, para. 10.4

³¹ UN Human Rights Committee (HRC), General Comment 35, Article 9 (Liberty and Security of Person), 16 December 2014, UN Doc CCPR/C/GC/35, para 38.

зарчимд нийцүүлэн хангалттай нарийвчлан тодорхойлсон үндэсний хууль тогтоомжид заасан гэмт хэргийг ойлгох бөгөөд энэ нь хүний эрх (тухайлбал, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө)-ийг хэрэгжүүлэх явдлыг дур зоргоор зөрчөөгүй байх ёстой. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль тогтоомжид заасан холбогдох зохицуулалт, хамгаалалт байгаа нөхцөлд засгийн газрууд уг эрхийн хамгаалалтыг алдагдуулсан захиргааны бусад журмыг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд улс орнууд ял шийтгэх зорилгоос гадуур хүнийг саатуулах, цагдан хорих нь төрийн хувьд хүний эрхийн ноцтой зөрчил юм. Гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийсэн гэх үндэслэлээр хэн нэгний эрх чөлөөг хасахдаа төрөөс “шүүхээс нотлох хүртэл хэнийг ч гэм буруутайд үл тооцох” зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зүй ёсны процедурын нийтлэг зарчмаар хэрэгжүүлэх ёстой гэсэн шаардлага тавигддаг. Энэ нь хүний эрх чөлөө, халдашгүй байдлыг хангах суурь хэм хэмжээ, олон улсын хүний эрх хамгааллын эрх зүйн зарчим юм.

VI. СААТУУЛАХ АЖИЛЛАГАА НЬ ЭРХ ЗҮЙН ТОДОРХОЙ БАЙХ ЗАРЧИМД НИЙЦСЭН, ДУР ЗОРГЫН ҮЙЛДЛЭЭС АНГИД БАЙХ ЁСТОЙ

22. ИУТЭОУП-ын 9(1)-д “хэнийг ч дур зоргоор баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй” хэмээн заасан. Мөн Аливаа хэлбэрээр саатуулагдсан, хоригдсон бүх хүнийг хамгаалах зарчмуудын цогц-ын 2 дугаар зарчимд “баривчлах, цагдан хорих, хорих арга хэмжээг зөвхөн хуульд заасан журмыг ягштал баримтлан уг зорилгоор эрх олгогдсон албан тушаалтан, этгээд хэрэгжүүлнэ” хэмээн заасан. Түүнчлэн, саатуулагдсан, цагдан хоригдсон хүмүүстэй харьцах харьцаа нь саатуулан хорих зорилготой нийцээгүй тохиолдолд уг саатуулах, цагдан хорих арга хэмжээг дур зоргын хэмээн үзнэ.³²

23. Дур зоргоор баривчлан саатуулахыг хориглох нь зайлшгүй баримтлах олон улсын хэм хэмжээ болохыг НҮБ-ын Дур зоргоор баривчлан саатуулах асуудлаарх ажлын хэсэг баталгаажуулсан.³³ Хуульд заасан үндэслэлээс гадуур баривчлах, цагдан хорих, саатуулахыг дур зоргын гэж үзнэ. Гэвч дотоодын хууль тогтоомжид заасны дагуу баривчлах, цагдан хорих, саатуулах нь ч дур зоргын байж болохыг НҮБ-ын Дур зоргоор баривчлан саатуулах асуудлаарх ажлын хэсэг мөн баталгаажуулсан.³⁴ Дур зоргын гэх ойлголтыг “хуулийн эсрэг” гэсэн ойлголттой адилтган үзэж болохгүй бөгөөд зохисгүй, гэм буруутай нь нотлогдоогүй байхад гэм буруутай гэж үзэх, хуулийн шударга процессын хэм хэмжээ дутмаг байх,³⁵ хуульд заасан үндэслэлтэй байх, зайлшгүй, тухайн нөхцөл байдалд тохирсон байх шаардлагад нийцээгүй³⁶ гэх зэргээр илүү өргөн хүрээнд тайлбарлах шаардлагатай. Цагдан хорих, саатуулахыг “хуулийн дагуу” гэж үзэхийн тулд эрх зүйн тодорхой байх зарчимд нийцсэн байх шаардлагатай. Эрх зүйн тодорхой байх зарчим нь хуулийг түүнийг хэрэгжүүлж байгаа этгээдүүдэд хялбар ойлгохоор тодорхой тогтоохыг шаарддаг бөгөөд ингэснээр тэдгээр нь өөрсдийн үйлдлийг хуулийн дагуу хэрэгжүүлэх боломжтой болно. Дотоодын хууль тогтоомж нь хэт өргөн хүрээтэй бол дур зоргын болох³⁷ бөгөөд эрх зүйн тодорхой байх шаардлагыг хангахын тулд хууль тогтоомж практикт хэрхэн хэрэгжихийг хүмүүс урьдчилан таамаглах боломжтой байх ёстой. Тухайн харилцааг зохицуулсан хэд хэдэн эрх зүйн зохицуулалт байгаа тохиолдолд энэ нь онцгой анхаарах асуудал бөгөөд шийдвэр гаргагчдад ижил нөхцөл байдалд аль хуулийг хэрэглэх дээр хувийн үзэмжээр хандах боломж олгодог. Энэ шалтгаанаар Эмнести Интернэшнл цагдаагийн алба хаагчдад өргөн эрх мэдэл олгосон түр саатуулах болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг аль алиныг нь зохицуулсан зэрэгцсэн, зөрчилтэй хуулиуд байгаа нь эрх зүйн тодорхой байх зарчмыг зөрчсөн бөгөөд дур зоргоор хандах боломжтой байгаад санаа зовниж байна.

24. ИУТЭОУП-аар хамгаалагдсан эрх, тухайлбал (19 дүгээр зүйлээр хамгаалагдсан) үзэл бодолтой байх,³⁸ түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх, (21 дүгээр зүйлээр хамгаалагдсан) хуран цуглах эрх чөлөө, (22

³² UN Human Rights Committee, General Comment 35, Article 9 (Liberty and Security of Person), 16 December 2014, UN Doc CCPR/C/GC/35, para 14.

³³ Working Group on Arbitrary Detention, Report, 24 December 2012, UN Doc. A/HRC/22/44 paras 37-75.

³⁴ UN Human Rights Committee, General Comment 35, Article 9 (Liberty and Security of Person), 16 December 2014, UN Doc CCPR/C/GC/35, para 12.

³⁵ 1134/2002, *Gorji-Dinka v. Cameroon*, para. 5.1; 305/1988, *Van Alphen v. Netherlands*, para. 5.8.

³⁶ UN Human Rights Committee (HRC), General Comment 35, Article 9 (Liberty and Security of Person), 16 December 2014, UN Doc CCPR/C/GC/35, para 12.

³⁷ UN Human Rights Committee, Concluding Observations, Ethiopia, UN Doc CCPR/C/ETH/CO/1 (2011) para 15.

³⁸ Human Rights Committee, Decision, *Zelaya Blanco v. Nicaragua*, 20 July 1994, Communication no. 328/1988, para. 10.3.

дугаар зүйлээр хамгаалагдсан) эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг³⁹ хууль ёсоор эдэлснийх нь төлөө шийтгэл болгон баривчлах, цагдан хорих нь дур зоргод хамаарна. Ялангуяа тайван хуран цуглах эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах төрийн үүрэг нь жагсаал, цуглааны үеэр болон түүний өмнө, хойно эерэг болон сөрөг үүргийг төрд бий болгодог болохыг онцлон тэмдэглэж байна. Сөрөг үүрэг нь тайван цуглаанд хөндлөнгөөс үндэслэлгүй оролцохгүй байхыг шаарддаг. Тухайлбал, улс орнууд тайван цуглаанд үндэслэлгүйгээр саад учруулахгүй байх, хууль ёсны шалтгаангүйгээр зохион байгуулагч болон оролцогчдод шийтгэл ногдуулахгүй байх үүрэгтэй.⁴⁰ Тайван цуглаан зохион байгуулагч, оролцогч нарт саад учруулахын тулд үндэслэлгүйгээр цагдан хорих, саатуулах нь ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйл заасныг зөрчөөд зогсохгүй 21 дүгээр зүйлд заасныг зөрчинө. Хүний болон ард түмний эрхийн талаарх Африкийн Хартиг тайлбарлах үүрэг бүхий Хүний эрх болон ард түмний эрхийн Африкийн Комисс “хариуцлага хүлээхээргүй үйлдэлд хүмүүсийг цагдан хорих, саатуулах нь ... тэдгээрийн эрх чөлөөг дур зоргоор хассан хэрэг болно” гэжээ.⁴¹

25. Ялангуяа Монгол Улсын хувьд, хүний эрх хамгаалагчдыг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай нь холбогдуулан түр саатуулж байгаа нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 7 дугаар зүйлд заасан хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байх, хуулиар нэгэн адил хамгаалуулах эрх болон ИУТЭОУП-ын 26 дугаар зүйлээр хамгаалагдсан эрхийг зөрчиж байгааг 2022 оны аравдугаар сард НҮБ-ын Дур зоргоор баривчлан саатуулах асуудал хариуцсан ажлын хэсэг тус улсад хийсэн айлчлалын дараа дахин сануулсан.⁴²

26. Хүнийг түрхэн хугацаагаар саатуулсан ч бай дүрэм, журам зөрчсөн л бол дур зоргоор гэж үзнэ. Хүнийг цагдаагийн газарт албадан авчирч, цагдаагийн камерт тавин таван минут цагдан хорьсон нь⁴³ Европын Хүний Эрхийн Конвенцын 5(1) дэх заалтыг зөрчсөн болохыг Европын Хүний Эрхийн Шүүх хүлээн зөвшөөрч шийдвэрлэсэн. Харьцангуй богино хугацаанд үргэлжилсэн нь энэхүү байр суурийг өөрчлөхгүй.⁴⁴

VII. СААТУУЛАГДСАН ХҮН БҮРТ ЦАГДАН ХОРЬСОН ШАЛТГААНЫ ТАЛААР АЛЬ БОЛОХ БОЛОМЖИТ ХУРДАН ХУГАЦААНД МЭДЭГДЭЖ, ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХИЙГ ХАНГАХ ЁСТОЙ

27. ИУТЭОУП-ын 9(1)-д баривчлагдсан хүн бүр эрх чөлөөг нь хасаж байгаа үндэслэлийн талаар мэдэх эрхтэй хэмээн заасан.⁴⁵ Уг эрх ямар ч тохиолдолд хэрэгжих ёстой. Дээрх шаардлагын үндсэн зорилго нь тухайн хүн цагдан хорьж, саатуулж байгааг хууль бус, үндэслэлгүй хэмээн үзсэн тохиолдолд уг арга хэмжээнд гомдол гаргах боломжийг олгох явдал юм. Үүнд тухайн хүнийг ямар хуулийн заалтын дагуу саатуулж, цагдан хорьж байгаа болон ийнхүү баривчлах, цагдан хорих болсон бодит үндэслэлийн талаар ойлгомжтой байдлаар тайлбарлах ойлголт аль аль нь хамаарна.⁴⁶

28. Үйлдсэн гэж сэжиглэж байгаа гэмт хэргийн ямар бүрэлдэхүүн тогтоогдож байгааг огт мэдээлэхгүйгээр саатуулагдаж байгаа хүмүүст аюулгүй байдлын үндэслэлээр баривчилж байна хэмээн мэдэгдэх нь хангалтгүй хэмээн НҮБ-ын ХЭХ дүгнэсэн.⁴⁷ Терроризмтой тэмцэхийн зэрэгцээ хүний эрх, үндсэн эрх чөлөөг дэмжих, хамгаалах асуудал хариуцсан НҮБ-ын тусгай илтгэгч Израиль ба Палестины эзлэгдсэн газар нутгийн талаарх тайландаа Баруун эрэгт Палестинчуудыг

³⁹ UN Human Rights Committee (HRC), General Comment 35, Article 9 (Liberty and Security of Person), 16 December 2014, UN Doc CCPR/C/GC/35, para 17.

⁴⁰ UN Human Rights Committee, General Comment 37, on the right to peaceful assembly (article 21), 16 September 2020, UN Doc CCPR/C/GC/37 para 23.

⁴¹ African Commission on Human and Peoples Rights, Decision, Constitutional Rights Project & Another v Nigeria, Communication No. 102/93, 31 October 1998, para 55.

⁴² UN Working Group on Arbitrary Detention, Report, Visit to Mongolia, 5 July 2023, UN Doc. A/HRC/54/51/Add.2, para 25.

⁴³ European Court of Human Rights, Novotka v Slovakia, Application no. 47244/99 (4 November 2003).

⁴⁴ European Commission of Human Rights (First Chamber), Järvinen v. Finland, Application no. 30408/96, (15 January 1998).

⁴⁵ This right is also recognised in Article 7(4) of the American Convention on Human Rights; Article 14(3) of the Arab Charter on Human Rights; Article 5(2) of the European Convention on Human Rights; Principle 10 of the Principles for the Protection of All Persons under Any Form of Detention or Imprisonment; The African Commission on Human and Peoples' Rights, Section M(2)(a) of the Principles and Guidelines on the Right to Fair Trial and Legal Assistance in Africa; Principle V of the Principles and Best Practices on the Protection of Persons Deprived of Liberty in the Americas; See Articles 55(2) and 60(1) of the International Criminal Court Statute, Rule 117(1) of the International Criminal Court Rules of Procedure and Evidence, Rule 53 bis of the Rwanda Rules, Rule 59 bis (B) of the Rules of Procedure and Evidence of the International Tribunal for the Prosecution of Persons Responsible for Serious Violations of International Humanitarian Law Committee in the Territory of the Former Yugoslavia since 1991.

⁴⁶ European Court of Human Rights: Shamayev and Others v Georgia Application no. 36378/02, (2005) para 413, Kortesio v Greece Application no. 60593/10, (2012) paras 58-62, Nechiporuk and Yonkalo v Ukraine Application no. 42310/04, (2011) paras 209-211; UN Human Rights Committee, Decision, Kelly v Jamaica UN Doc. CCPR/C/41/D/253/1987 (1991) para 5.8.

⁴⁷ UN Human Rights Committee, Decision, Adolfo Drescher Caldas v Uruguay, UN Doc. A/38/40 Supp. 40 at 192 (1983) para 13.2; See also UN Human Rights Committee, Concluding Observations: Sudan, UN Doc. CCPR/C/79/Add.85 (1997) para 13; UN Human Rights Committee, Decision, Nechiporuk and Yonkalo v Ukraine, Communication no. 42310/04

баривчлах болон цагдан хорих асуудлыг зохицуулсан Израилын цагдаагийн журамд эрх баригчдыг палестинчуудыг баривчлах үедээ цагдан хорих болсон үндэслэлийн талаар мэдэгдэхийг шаарддаггүй практикийг шүүмжилсэн. “Хүнийг саатуулж, цагдан хорих болсон үндэслэлийн талаар мэдэгдэхгүй байхыг зөвтгөх шалтгаан байхгүй” хэмээн Тусгай илтгэгч онцолсон.⁴⁸ Энэ талаар сэжиглэгдэж байгаа этгээд, түүний өмгөөлөгчийн аль алинд нь мэдэгдэх ёстой хэмээн Америк хоорондын шүүх тайлбарласан.⁴⁹

29. Цаг хугацааны тухайд, ИУТЭОУП-ын 9(2)-т баривчлах болсон шалтгааныг баривчлах үедээ мэдэгдэх ёстой хэмээн тодорхой заасан. Мөн Европын Хүний Эрхийн Конвенцын 5(2) болон Америк дахь Эрх чөлөөгөө Хасуулсан Хүмүүсийн Хамгаалалтын талаарх Зарчим болон Сайн туршлагын V-д (Америк хоорондын Комиссын баталсан) баривчлах болсон шалтгааныг тэр даруй мэдэгдэх шаардлагыг тодорхойлсон. Мэдэгдсэн цаг хугацааг ерөнхийдөө хэргийн нөхцөл байдлыг харгалзан үнэлдэг. Орчуулагч олох, баривчлагдсан хүн баривчлах болсон үндэслэлийн талаар хангалттай мэдэж байсан, үндэслэлийг мэдэгдэхээс өмнө байцаалт аваагүй зэрэг зайлшгүй хугацаа хожимдсон байдлыг хүлээн зөвшөөрч болно.

30. Хүн эрхээ эдлэхийн тулд, юуны өмнө эрхтэй гэдгээ мэдэх ёстой. Баривчлагдаж, саатуулагдаж байгаа хүн бүрт эрхийг нь мэдэгдэх, эрхээ хэрхэн эдлэх талаар тайлбарлуулах эрхтэй байхыг олон улсын хэм хэмжээ шаарддаг.⁵⁰ Эдгээр хэм хэмжээ нь дараах эрхийн талаар мэдэгдэхийг шаарддаг.

- 1.1. гуравдагч этгээдэд мэдэгдэх эрх,⁵¹
- 1.2. хуульчийн зөвлөгөө авах эрх (сонгогдсон болон томилогдсон хуульч)⁵²
- 1.3. эмнэлгийн тусламж авах эрх,⁵³
- 1.4. цагдан хорих нь хууль ёсны эсэх талаар эсэргүүцэх, гомдол гаргах эрх,⁵⁴
- 1.5. өөрийгөө буруутгахгүй байх, дуугүй байх эрх,⁵⁵
- 1.6. зүй бус харьцсан, эсхүл нөхцөл байдлын талаар мэдэгдэх, гомдол гаргах эрх.⁵⁶

31. Дээрхтэй төстэй байдлаар Эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцаанаас урьдчилан сэргийлэх НҮБ-ын гэрээний байгууллага болох Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх Дэд хороо (SPT/ЭШУСДХ) цагдан хоригдсон, саатуулагдсан этгээдийн гэр бүл, өмгөөлөгч нартай харилцах, эмчийн үзлэгт хамрагдах зэрэг эрх зүйн үндсэн баталгааг бүрэн хэрэгжүүлэхийг зөвлөсөн. Саатуулагдсан хүмүүст өмгөөлөгч авах эрхийг нь олгохын тулд “Оролцогч улс эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнд баривчлагдсан цагаасаа эхлэн хараат бус хуульчид нэн даруй хандах эрхийг хуулиар болон практикт олгох, шаардлагатай тохиолдолд олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн үр дүнтэй хууль зүйн туслалцаа үзүүлнэ.”⁵⁷ Эдгээр хууль зүйн туслалцаа нь эрх чөлөөгөө хасуулсан хүмүүст тэдгээрийн эрх, холбогдох эрх зүйн процесс болон процессын явцад гарч болох шийдвэрүүдийн үр дагаврын талаар хангалттай мэдээлэлтэй байх баталгааг хангана. Цагдан хоригдсон, саатуулагдсан хүмүүс эдлэх ёстой эрх, хэргийн эрх зүйн процесс, гарах шийдвэрийн үр дагаварын талаарх мэдлэг дутмаг байх нь тэднийг эмзэг байдалд хүргэдэг” хэмээн Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон, харьцаж, шийтгэхээс Урьдчилан сэргийлэх Дэд Хороо тайлбарласан.⁵⁸

⁴⁸ Special Rapporteur on human rights and counter-terrorism, Israel and the Occupied Palestinian Territories, UN Doc. A/HRC/6/17/Add.4 (2007) para 22.

⁴⁹ Inter-American Court of Human Rights, Decision, *Tibi v Ecuador*, (2004) para 109.

⁵⁰ Committee Against Torture, General Comment no. 2, Implementation of article 2 by States parties, 24 January 2008, UN doc CAT/C/GC/2, para 13; Principles 13 and 14 of the Body of Principles for the Protection of All Persons under Any Form of Detention or Imprisonment.

⁵¹ Principle 16 the Body of Principles for the Protection of All Persons under Any Form of Detention or Imprisonment.

⁵² Principle 17(1) of the Body of Principles for the Protection of All Persons under Any Form of Detention or Imprisonment; Principle 5 of the UN Basic Principles of the Role of Lawyers, Article 55(2)(c) of the Statute of the International Criminal Court.

⁵³ Principle 24 the Body of Principles for the Protection of All Persons under Any Form of Detention or Imprisonment.

⁵⁴ Article 9(4) ICCPR, «anyone who is deprived of his liberty by arrest or detention shall be entitled to take proceedings before a court, in order that that court may decide without delay on the lawfulness of his detention and order his release if the detention is not lawful.»

⁵⁵ UN Human Rights Committee Concluding Observations: France, UN Doc. CCPR/C/FRA/CO/4 (2008) para 14, Netherlands, UN Doc. CCPR/C/NLD/CO/4 (2009) §11; CAT: Mexico, UN Doc. CAT/C/75 (2003) para 220 (e).

⁵⁶ UN Human Rights Committee (HRC), General Comment 35, Article 9 (Liberty and Security of Person), 16 December 2014, UN Doc CCPR/C/GC/35, para 42.

⁵⁷ Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, Report, Visit to Bulgaria, 28 October 2022, UN Doc CAT/OP/BGR/ROSP/1, paras 58-59; Rule 41 of the Rules of Procedure and Evidence of the International Tribunal for the Prosecution of Persons Responsible for Serious Violations of International Humanitarian Law Committee in the Territory of the Former Yugoslavia since 1991.

⁵⁸ Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, Report, Visit to Australia, 20 December 2023, UN Doc CAT/OP/AUS/ROSP/1 para 47.

32. Сэжигтэн эрх чөлөөгөө хасуулсан үеэсээ эхлэн байцаалтын үеэр хуульчийг биеэр байлцуулах, (тухайлбал мэдүүлэг өгөхдөө) баталгаагаар хангагдахын тулд хуульчтай нэн даруй холбогдох боломжтой байна.⁵⁹ Ийнхүү хуульч авах эрх нь түүнд холбогдох асуудал гэмт хэрэг, эсхүл гэмт хэргийн шинжгүй эсэхээс үл хамааран хэрэгжих ёстой.⁶⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 13-т баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүл, өмгөөлөгчид хуульд заасан хугацааны дотор мэдэгдэнэ хэмээн заасныг онцлон тэмдэглэж байна. Эмнести Интернэшнл нь энэхүү процедурын баталгааг практикт хэрэгжүүлэх нь чухал гэдгийг хүлээн зөвшөөрч, эрх чөлөөгөө хасуулсан хүмүүст цагдан хоригдсон тухайгаа гэр бүлийн гишүүн болон ойр дотны хүмүүстээ нэн даруй мэдэгдэх боломжтой байх талаарх НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхээс урьдчилан сэргийлэх дэд хорооны зөвлөмжид анхаарал хандуулахыг Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцээс хүсэж байна.⁶¹ Хууль сахиулах байгууллагын ажилтнууд сэжигтнийг баривчилсны дараа тэдэнд хууль зүйн туслалцаа авах эрхийг ойлгуулж, уг эрхийг зохих ёсоор хүндэтгэн, дэмжлэг үзүүлэх ёстой хэмээн НҮБ-ын Дур зоргоор баривчлан саатуулах асуудлаарх ажлын хэсэг тодорхой тэмдэглэсэн.⁶² Дээрх эрхээ хэрэгжүүлэх нь прокурор, мөрдөн байцаагч, цагдан хорих газрын захиргаанаас хамааралгүй байх ёстой гэдгийг НҮБ-ын ЭШУСДХ хүлээн зөвшөөрсөн. Улмаар, мөрдөн байцаагч, прокурорын зүгээс ойр дотны хүмүүстээ мэдээлэх эрхийг хязгаарласан аливаа шийдвэр нь мөрдөн байцаалтын ажиллагаатай холбоотой бодитой, нотлох үндэслэлтэй байх ёстой бөгөөд шүүхийн хяналтад байх ёстой.⁶³

VIII. ДУР ЗОРГООР СААТУУЛАГДСАН ХҮН БҮР ЗӨРЧИГДСӨН ЭРХЭЭ СЭРГЭЭЛГЭХ ЭРХТЭЙ БАЙХЫГ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙГЭЭР ШААРДДАГ

33. Олон улсын эрх зүйд дур зоргоор саатуулагдсан хүн бүр зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрхтэй байхыг шаарддаг.⁶⁴ Зөрчигдсөн эрхээ сэргээлгэх нь хүмүүст хүний эрхийн зөрчлийг үр дүнтэй шийдвэрлүүлэх эрх эдлэх боломж олгодог бөгөөд энэ нь олон улсын заншлын эрх зүйд тусгагдсан⁶⁵ “олон улсын хүний эрхийн эрх зүйн үндсэн зарчим” юм.⁶⁶ Хүний эрхийн зөрчлийн хохирогч бүр зөрчигдсөн эрхээ үр дүнтэй сэргээлгэх эрхтэй. Энэ нь олон улсын хүний эрхийн эрх зүйн зарчмаас үүдэлтэй бөгөөд түүнийг зөрчсөн зөрчил бүрт үр дүнтэй эрх сэргээлгэх арга хэмжээ авах төрийн үүргийг сөхдөг.⁶⁷

34. Зөрчигдсөн эрхийг сэргээлгэх эрхийг анх НҮБ-ын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 8 дугаар зүйлд баталгаажуулсан бөгөөд хүн бүр хуулиар олгогдсон үндсэн эрхээ зөрчигдсөн тохиолдолд үндэсний шүүхээр үр дүнтэй сэргээлгэх эрхтэй. ИУТЭОУП-ын 2(3)-т зөрчигдсөн эрхээ үр дүнтэй сэргээлгэх ерөнхий эрхийг тусгасан нь онцгой ач холбогдолтой. ИУТЭОУП-д улс орнууд “зөрчигдсөн эрхээ сэргээлгэхийг хүссэн аливаа этгээдийн эрхийг эрх бүхий шүүх, захиргааны.... байгууллагаар хамгаалуулах боломжийг нь хөгжүүлэх” үүрэгтэй болохыг онцлон тэмдэглэсэн.⁶⁸ НҮБ-ын гэрээний хороодоос улс орнууд гэрээнд заасан хүний эрхийг хэрэгжүүлэхийн тулд холбогдох бүх арга хэмжээг авах үүрэг нь “шүүхийн болон бусад үр дүнтэй эрх сэргээх” арга хэмжээг авах үүргийг багтаана хэмээн тайлбарласан.⁶⁹ Тухайлбал, “учирсан хохирлыг

⁵⁹ Committee against Torture, Concluding Observations on the second periodic report of Mongolia, 5 September 2016, UN Doc. CAT/C/MNG/CO/2, para 12.

⁶⁰ Working Group on Arbitrary Detention: Opinions adopted by the Working Group on Arbitrary Detention at its sixty-fifth session, 14–23 November 2012 - No. 48/2012 (Islamic Republic of Iran) UN Doc. A/HRC/WGAD/2012/48, para 22; A/HRC/WGAD/2013/10; Opinions adopted by the Working Group on Arbitrary Detention at its sixty-sixth session, 29 April–3 May 2013 – No.10/2013 (United States of America) UN Doc A/HRC/WGAD/2013/10 para 32.

⁶¹ Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, Report, Visit to Kazakhstan, 7 February 2019, UN Doc CAT/OP/KAZ/1 para 46.

⁶² UN Working Group on Arbitrary Detention, Report, Visit to Mongolia, 5 July 2023, UN Doc. A/HRC/54/51/Add.2, para 48.

⁶³ Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, Report, Visit to Kazakhstan, 7 February 2019, UN Doc CAT/OP/KAZ/1 para 46.

⁶⁴ Article 9(5) of the ICCPR provides that «Anyone who has been the victim of unlawful arrest or detention shall have an enforceable right to compensation.»

⁶⁵ UN Human Rights Council, Report of the United Nations High Commissioner for Human Rights and reports of the Office of the High Commissioner and the Secretary-General Promotion and protection of all human rights, civil, political, economic, social and cultural rights, including the right to development (10 May 2016), A/HRC/32/19, para. 6.

⁶⁶ Prosecutor v. Andrii Rwamakuba, Case No. ICTR-98-44C, Decision on Appropriate Remedy, para 40 (31 January 2007); Prosecutor v. Andrii Rwamakuba, Case No. ICTR-98-44C-A, Decision on Appeal Against Decision on Appropriate Remedy, paras 23-5 (13 September 2007); and Cantoral-Benavides v. Perú, 2001 Inter-Am. Ct. H.R. (ser.C) No. 88, para 40.

⁶⁷ Permanent Court of International Justice, Chorzów Factory (Germany v. Poland), 1928, (series A) No. 17, para 73.

⁶⁸ ICCPR, Article 2(3). See also ICERD, Article 6; UN General Assembly, Convention Against Torture, 10 December 1984, Article 4.

⁶⁹ UN Committee on Economic, Social and Cultural Rights, General Comment 3 on the nature of States parties obligations (Art. 2, par. 1), paras 3, 5; UN Committee on the Elimination of Discrimination against Women, General Recommendation 28 on the core obligations of States parties under article 2 of the Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women, paras 30 – 32.

барагдуулахгүйгээр зөрчигдсөн эрхийг зохистой сэргээх” үүргийг хэрэгжүүлэх боломжгүй хэмээн үзсэн.⁷⁰ НҮБ-ын Дур зоргоор баривчлан саатуулах асуудлаарх ажлын хэсгийн тайлбарласнаар шүүхээр зөрчигдсөн эрхээ сэргээлгэх нь хууль ёсны зарчмыг хангахад чухал ач холбогдолтой.⁷¹

35. Саатуулах нь хууль ёсны эсэхийг хянуулахаар шүүхэд гомдол гаргах эрх нь бие даасан хүний эрх бөгөөд уг эрхийг хамгаалаагүй нь хүний эрхийн зөрчил юм. Энэ нь түр саатуулах болон захиргааны журмаар саатуулах зэрэг эрх чөлөөг хязгаарласан бүх хэлбэрт хамаарна.⁷² Энэ нь хувь хүний эрх чөлөө, бие махбодын бүрэн бүтэн байдлыг дур зоргоор баривчлах, саатуулах, нууцаар цагдан хорих, эх орноос нь хөөх, хүчээр алга болгох, эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх эрсдэлээс хамгаалахад чиглэсэн зөрчигдсөн эрхээ шүүхээр сэргээлгэх арга юм. Түүнчлэн энэ нь саатуулагдсан, цагдан хоригдсон хүний хаана байгаа, түүний эрүүл мэндийн байдал болон эрх чөлөөг хасах шийдвэр гаргаж, хэрэгжүүлж байгаа төрийн эрх бүхий этгээдийг тодорхойлох хэрэгсэл юм.⁷³
36. Түүнчлэн, НҮБ-ын Дур зоргоор баривчлан саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн Цагдан хорих арга хэмжээний дур зоргын болон хууль ёсны эсэхийг хянуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийн талаарх 7 дугаар удирдамжид цагдан хорьсон нь дур зоргын болон хууль ёсны эсэхийг хянуулахаар анх удаа гомдол гаргахаас өмнө хүлээх хугацаа тогтоож болохгүй хэмээн үзсэн.⁷⁴ Засгийн газрууд цагдан хорих арга хэмжээ нь хууль ёсны эсэх талаар гомдол гаргах, хэрэв хууль бус бол тухайн хүнийг суллах журмыг бий болгох шаардлагатай. Саатуулагдсан хугацааны туршид энэ журмыг баримтлах ёстой. Эдгээр процедурыг хялбар бөгөөд шуурхай⁷⁵ хэрэгжүүлэх ёстой. Цагдан хоригдож байгаа этгээд төлбөр төлөх боломжгүй бол үнэ төлбөргүй байна.⁷⁶
37. Олон улсын сайн туршлагаас үзэхэд үр дүнтэй хяналтыг баталгаажуулахын тулд улс орнууд олон улсын эрх зүйн зөрчилд идэвхтэй хяналт хэрэгжүүлэхийг шаарддаг. Дур зоргоор цагдан хорьсон, саатуулсан талаарх бүхий л гомдлыг тэр даруй, нягт нямбай, шударгаар шалгах шаардлагатай. Хууль эрх зүйн болон институцийн тогтолцоо нь дур зоргоор цагдан хорьсон, саатуулсан гэх тохиолдлыг үр дүнтэй мөрдөн шалгах боломжийг бүрдүүлэх шаардлагатай бөгөөд тухайн мөрдөн шалгах ажиллагааны үр дүн, үр дагаврын талаарх бүртгэлийг үр дүнтэй хөтлөх шаардлагатай.⁷⁷ Энэ нь тухайн зөрчил дахин давтагдахгүй байх баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ. Хүмүүсийг дур зоргоор цагдан хорьсон, саатуулсан тохиолдолд эрхийг нь үр дүнтэй сэргээхийн тулд хохирогчдын гомдол гаргах эрх баталгаажсан байх ёстой.

IX. ДҮГНЭЛТ

38. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа олон улсын эрх зүйн хэм хэмжээ, түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу үндэсний дотоодын хууль тогтоомжоор дур зоргоор цагдан хорих, саатуулахыг тодорхой хориглосон. Энэхүү хариу бичигт дурдсан олон улсын эрх зүйн хэм хэмжээ нь маргааныг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ хэмээн итгэж байна.
39. Энэхүү *amicus curiae* нь Үндсэн хуулийн цэцээс маргаан шийдвэрлэхэд хэрэг болно хэмээн Эмнести Интернэшнл итгэж байна.

⁷⁰ UN Committee on the Elimination of Discrimination against Women, General Recommendation, 28 on the core obligations of States parties under article 2 of the Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women, para 32.

⁷¹ Working Group on Arbitrary Detention, Report, United Nations Basic Principles and Guidelines on Remedies and Procedures on the Right of Anyone Deprived of Their Liberty to Bring Proceedings Before a Court, 6 July 2015, UN Doc A/HRC/30/37, para 3.

⁷² Human Rights Council, Resolution 15/18 on Arbitrary detention, 6 October 2010, paras 4(d)-(e).

⁷³ Working Group on Arbitrary Detention, Report, United Nations Basic Principles and Guidelines on Remedies and Procedures on the Right of Anyone Deprived of Their Liberty to Bring Proceedings Before a Court, 6 July 2015, UN Doc A/HRC/30/37, para 2.

⁷⁴ Working Group on Arbitrary Detention, Report, United Nations Basic Principles and Guidelines on Remedies and Procedures on the Right of Anyone Deprived of Their Liberty to Bring Proceedings Before a Court, 6 July 2015, UN Doc A/HRC/30/37, para 61.

⁷⁵ European Court of Human Rights, Decision, Grand Chamber, *Chahal v United Kingdom*, Application no. 22414/93, (1996) para 130.

⁷⁶ Principle 32(2), UN Body of Principles for the Protection of All Persons under Any Form of Detention or Imprisonment.

⁷⁷ See, for example UN Human Rights Committee, General Comment No. 21: Humane treatment of persons deprived of their liberty (Article 10), UN Doc. HRI/GEN/1/Rev.9 (Vol. I) at pp. 202-203, paras 6-7.

Х. ХАВСРАЛТ

1. Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт түр саатуулах 6 цагийн хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцохоор заасан нь хүний эрхийг хүндэтгэдэг, ардчилсан улс орнуудын сайн туршлага болон олон улсын хүний эрхийн эрх зүйд нийцэж буй эсэхэд хариулна уу.
2. Хүний эрхийг хүндэтгэдэг, ардчилсан улсуудын сайн туршлага болон олон улсын хүний эрхийн эрх зүйн үүднээс дараах асуултад хариулт өгнө үү.
 - 2.1. Цагдаагийн алба хаагч (хууль сахиулагч) ямар тодорхой үндэслэлээр хүнийг түр саатуулах (шүүхийн эсхүл прокурорын зөвшөөрөлгүйгээр)-аар хуульчилсан байдаг вэ, уул үндэслэлийн талаарх сайн туршлагад Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасан үндэслэл нийцдэг үү, эдгээр үндэслэл хангалттай тодорхой эсэх;
 - 2.2. Түр саатуулах хугацаанд хязгаарлалт тавьдаг эсэх, тийм бол уул хугацааг хэзээнээс эхэлж тоолдог, энэ талаарх сайн туршлагад Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2 дахь хэсэг нийцдэг эсэх;
 - 2.3. Түр саатуулах байр гэх ойлголт байдаг эсэх, байдаг бол түүнд юуг багтаан ойлгодог, хүнийг түр саатуулах эрх бүхий албан тушаалтан өөрийн хяналтад оруулсан үеэс саатуулах байр хүртэлх хугацааг хуульд заасан түр саатуулах хугацаанд хамааруулж үздэг эсэх, хэрэв түр саатуулах байранд хүргэх болон байранд хүргэснээс хойших хугацааг ялгаатайгаар зохицуулсан улс байгаа тохиолдолд хугацааны хязгаарлалт тогтоосон эсэх, энэ талаарх сайн туршлагад Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2 дахь хэсэг нийцдэг эсэх;
 - 2.4. Түр саатуулах ямар журам (процедур)-ыг хуульчилж баримталдаг вэ, тухайлбал ямар албан тушаалтан хүнийг ямар үндэслэлээр хаана яаж ямар хугацаагаар түр саатуулах журам үйлчилдэг, энэ журмыг хуулиар зохицуулдаг эсэх, уул журмын талаарх сайн туршлагад Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 26 болон бусад зүйлд заасан журам нийцдэг эсэх;
 - 2.5. Түр саатуулагдсан хүн түр саатуулах үедээ эсхүл тодорхой хугацааны дотор түр саатуулагдсан үндэслэлээ мэдэх эрх, мөн гэмт хэрэг эсхүл зөрчилд буруутгагдаж буй тохиолдолд энэ тухайгаа мэдэх эрх, гэр бүлийнхэн, өмгөөлөгчдөө мэдэгдэх, хууль зүйн туслалцаа авах зэрэг эрх эдэлдэг үү, эдэлдэг бол эдгээр эрхийг хэзээ эдэлдэг вэ, эдгээр эрхийн талаарх сайн туршлагад Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг болон бусад заалт нийцдэг эсэх, Монгол Улсад түр саатуулагдсан хүнд эдгээр эрхийг эдлүүлдэг эсэх;
 - 2.6. Түр саатуулсан нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу байсан эсэхийг шүүхээр хянуулдаг эсэх, шүүхээс энэ хяналтыг заавал хэрэгжүүлдэг үү эсхүл тухайн саатуулагдсан хүний гомдлоор хэрэгжүүлдэг үү;
 - 2.7. Түр саатуулах үндэслэл, журам, нь эрүүгийн гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад хойшлуулшгүй тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчлахаас ялгаатай эсэх, ялгаатай бол тэдгээрийн үндэслэл, журам нь ямар ялгаатай (түр саатуулсан хугацаа нь баривчилсан хугацаанд багтаж тоологддог эсэх)